



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 04 өдөр

Дугаар А1625

Алтай хот

Урамшуулал олгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.7 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 56 дугаар тогтоолоор батлагдсан "Аваргыг аймагтаа" дэд хөтөлбөрийн 3.2.1 дэх заалт, аймгийн Засаг даргын Зөвлөлийн 2020 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 29 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Волейболын идэрчүүдийн улсын аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцон гуравдугаар байр эзэлсэн аймгийн идэрчүүдийн эмэгтэй шигшээ багийг мөнгөн шагналаар шагнаж урамшуулсугай.

2. Шаардагдах 3000000 (Гурван сая) төгрөгийг Орон нутгийн төсвийн хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ч.Бат-Эрдэнэ)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс (С.Байгальмаа)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ж.ГАНБАТ